



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас: 7575-1155, Факс: 7046-2550  
И-мэйл: zavkhan.zdtg@gmail.com

2024.04.02

№

6/292

санай

-ны №

**ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ**

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 224 дахь хэсэгт тусгагдсан орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх "Дөрвөлжин сумын Онц багийн нутагт элсний нүүдлийг хамгаалах хайс хийж, мод тарих" ажлын гүйцэтгэчийг шалгаруулж өгнө үү. 70,000,000

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Д.АЗЖАРГАЛ




*Handwritten signature: Д. Цэрэнмахамад*

Тоот-С5-2024

8109090416

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
 ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
 ГҮЙЦЭТГЭГЧ



Э.МЯГМАРЖАВ

ДӨРВӨЛЖИН СУМЫН ОНЦ БАГИЙН НУТАГТ ЭЛСЭНИЙ НҮҮДЛЭЭС  
 ХАМГААЛАХ ХАЙС ХИЙЖ МОД ТАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН  
 ТОДОРХОЙЛОЛТ

Үзүүлэлт	Хэмжээ ба шаардлага
ТАЛБАЙ СОНГОЛТ, ХЭМЖЭЭ	<ul style="list-style-type: none"> <li>• 5 га</li> <li>• Хамгаалалтын зурвас байгуулах талбайг гүйцэтгэгч Сумын Засаг даргатай зөвшилцөн сонгоно.</li> </ul>
БЭЛТГЭЛ АЖИЛ	<ul style="list-style-type: none"> <li>• Хамгаалалтын зурвас байгуулах ажилд улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах</li> <li>• Хамгаалалтын зурваст байгуулах ажилд ашиглах техник тоног төхөөрөмжүүдийн техникийн үйлчилгээг хийж ажилд гаргахад бэлтгэх</li> <li>• Хамгаалалтын зурвас байгуулах ажлын технологийн карт боловсруулах, ажилчдад танилцуулах</li> <li>• Хамгаалалтын зурвас байгуулах талбайг сонгож тэмдэгжүүлэх</li> <li>• Нутгийн иргэдэд танилцуулга, уулзалт хийж, мал бэлчээхийг хориглох талаар мэдэгдэх</li> <li>• Ажил гүйцэтгэх хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж, ажлын явцын талаар мэдэгдэнэ.</li> </ul>
ХАШАА БАРИХ	<ul style="list-style-type: none"> <li>• Хашааны шон газрын гадаргаас 1,6 метр өндөртэй, шон хоорондын зай 3 метр байх байна.</li> <li>• Хашааны шонгийн нийт урт 2,0 метр урт, 40мм диаметртэй төмөр хийцтэй байх бөгөөд шонг 0,4 метр гүнд суулгаж, бетон суурь цутгана. Булан бүрийн шонд 2 тулгуур хийж бэхэлнэ.</li> <li>• Хашааны шон хооронд 3 эгнээгээр эрчилсэн өргөстэй утсаар татаж бэхэлнэ.м</li> <li>• Хашааны тор нь 7x7 см хэмжээтэй нүдтэй, 3 мм-ийн гантай сүлжмэл төмөр тор байх бөгөөд хашааны төмөр шонтой бэхэлсэн байна.</li> <li>• Газрын налуу, жалгын ховилоор, хашаан доогуур мэрэгч амьтан орохоос хамгаалах тор татна.</li> <li>• Усны эх үүсвэр, газрын налууг харгалзан явган хүн, автомашины орц, гарцыг гаргах, автомашинд 3-4 метр өргөн, явган хүнд 1-2 метр өргөн хаалгыг суурилуулна.</li> <li>• Мал бэлчээхийг хориглосон анхааруулах самбар байршуулна.</li> </ul>
ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС БАЙГУУЛАХ	<ul style="list-style-type: none"> <li>• Мод тарих ажлын технологийн картыг батлуулж мөрдөн ажиллана.</li> <li>• "Навчит модны суулгац. Техникийн шаардлага" MNS 6141:2010, стандартад заасан 3 настай улиас, бургас, хайлаас, харганын суулгац ашиглана.</li> <li>• Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах арга. Ерөнхий шаардлага MNS 6258:2011 стандартын дагуу суулгацын нүхийг бэлтгэнэ. "Улиасны суулгац. Ерөнхий шаардлага" MNS 6257:2011 стандартуудад нийцсэн суулгацуудыг хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд хэрэглэнэ.</li> <li>• Суулгацыг хаврын мод тарилтын хугацаанд хийх бөгөөд шаардлагатай бол намрын мод тарилтын хугацаанд нөхөн</li> </ul>

	<p>тарилт хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тарилтын схем эгнээ хооронд 3-4 метр, мод хооронд 2,5-3 метр байна. 1 га талбайд 600-аас багагүй суулгац байна.</li> <li>• Тарьсан суулгацыг арчлах, гаднын хүчин зүйлээс хамгаалах, тогтмол усалгааны ажил гүйцэтгэнэ.</li> <li>• Усалгааны асуудлыг зөөврийн усаар эсвэл гар худаг гаргаж шийдвэрлэнэ (газрын доорх ус 4-5 метр түвшинд байна)</li> <li>• Технологийн картын дагуу усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгэнэ.</li> <li>• Хашаа, усалгааны системийн хэвийн ажиллагааг тогтмол хангаж, засварлана.</li> <li>• Гүйцэтгэгч гэрээний хугацаанд мод тарьсан талбай, эд хөрөнгө, тоног төхөөрөмж, суулгацын бүрэн бүтэн байдлыг хариуцна.</li> <li>• Гүйцэтгэгч хамгаалалтын зурвас байгуулсан талбайн арчилгаа усалгаа, хамгаалалтын хашаа, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг 3 жилийн хугацаанд хариуцан харуул томилон ажиллуулна.</li> </ul>
<p>ТАЛБАЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Мод тарьсан талбайг аймгийн Засаг даргын томилсон ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгнө.</li> <li>• Актыг тарьсан модны тооллого, амьдралтын хувь, ажлын даалгаварт дурдсан бүх бүрдлийг шалгаж 3 хувь акт үйлдэнэ.</li> <li>• Амьдралтын хувийг тогтоохдоо нийт талбайд тооллого хийж таримлын амьдралт 75 хувиас дээш</li> <li>• Ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил гологдол арилгасны дараа "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, санхүүжүүлэх, таримал ойг улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна.</li> <li>• Суулгасан суулгац нь 50-74.9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 100 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө.</li> <li>• Суулгасан суулгац нь 25-49.9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна.</li> <li>• Суулгасан суулгац нь 24.9 хүртэл хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ</li> <li>• Ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ.</li> </ul>

Үе шатны хуваарь

№	Ажлын нэр, тодорхойлолт	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	5 га	2024.05.01-ний дотор
2	Хашаа барих	5 га	2024.05.01-ний дотор
3	Навчит төрлийн суулгац тарих	5 га	2024.05.20-ний дотор
4	Усалгааны систем суурилуулах	5 га	2024.05.20-ний дотор
5	Зөрчил гологдол арилгах	5 га	2024.10.01-ний дотор
6	Талбайг хүлээлгэн өгөх	5 га	2024.10.01-ний дотор
7	Тайлан ирүүлэх	2 удаа	Хагас, бүтэн жилээр
8	Харуул хамгаалалт, усалгаа арчилгаа	5 га	3 жилийн хугацаанд

Боловсруулсан: Ойн албаны дарга

Б.Нямцэнд